

ДӨРВӨЛЖИН ҮСГЭЭР ҮЛДЭЖ ИРСЭН  
ХУБИЛАЙ ХААНЫ ГЭРЭЭС

Ш. Баатар\*

*Оршил болгох нь*

Монголын Их Юань гүрний их хаан Хубилай сэцэн хаан (1215-1294)-ы зарлигаар 1269 онд Төвдийн Сажа ёсны<sup>1</sup> Пагва лам Лодойжалцан (1234-1279) төвд үсгээс эх авч монгол хэлний зүй тогтоолд тохируулан зохиосон бичгийг [1] бид **дөрвөлжин үсэг/ дөрвөлжин бичиг** хэмээн нэрлэж ирсэн билээ. Их Юань төрийн хэргийг нэг зуу орчим жил хөтөлсөн дөрвөлжин үсгээр бичсэн монгол, хятад хэлний бичгийн дурсгал олон бий [2,5,6]. Эдгээр дөрвөлжин үсгийн дурсгалд хааны зарлиг, хөшөө чулууны бичээс, ханын бичээс, агуйн бичээс<sup>2</sup>, барласан ном судрын тасархай болоод пайз, тамга, зоос мөнгө, ваар шаазан зэрэг дээрх бичээс орно. Дөрвөлжин бичигээрх дурсгалуудыг Монгол улс, Өвөр Монгол болоод Орос, Япон, Солонгос, Америк, баруун Европын олон оронд эрчимтэй судлаж, цөөнгүй ном товхимол гарсан билээ. Манай зарим судлаачдын зөвхөн хааны ордонд хэрэглэгдэж байсан мэтээр үздэг энэхүү дөрвөлжин бичиг нь төвд, самгард, хятад, солонгос, түрэг зэрэг харь хэлний үгийг нарийн тэмдэглэх галиг үсгийн шаардлагыг бүрэн хангасан өвөрмөц онцлог бүхий бичиг байсан ажээ. Дөрвөлжин үсгээр бичсэн хятад хэлний бичгийн дурсгал нэлээд үлдсэн байна [5]. Он цагийн эргэлтэд дэлхийн бусад улс оронд дөрвөлжин үсгийн дурсгал мэр сэр олдсоор байгаагийн нэгэн баримт бол Турк Улсын Истанбул<sup>3</sup> хотын Истанбулын их сургуулийн номын сангийн музейн хөмрөгт хадгалагдаж буй *Majma' al-'Aje'ib'* хэмээх номын завсраас олдсон нэг хуудас цаасан дээрхи Хубилай сэцэн хааны гэрээс юм. Истанбулын

\* АНУ-ын Бөркелей дахь Калифорны их сургуулийн Зүүн Өмнөд Ази судлалын хүрээлэн

<sup>1</sup> *sa skya*- Төвдийн Бурханы шашны дөрвөн их ёсны нэг. Сажагийн ёс нь улааны шашинд орох бөгөөд Монголын Бурханы шашны түрүү дэлгэрэлтэнд багтана.

<sup>2</sup> *Мангутын агуйн бичээс*- Байгалийн чанд дахь Буриадын харуулын Юренский тосгонд 1860-аад оны үед олдсон. А.А. Бобровников. Памятники Монгольского Квадратного Письма. Санктпетербургь, 1870.

<sup>3</sup> *Стамбул*- Хуучин нэр Constantinople, Истан нь ястан, бул нь полис (хот) гэсэн герег үгийн түрэгжсэн дуудлага

<sup>4</sup> *Сурч танин мэдэхүйн цуглуулга буюу Нэвтэрхий толь*

их сургуулийн профессор Сүхэйл Өнвер<sup>5</sup> номын сангуудын хуучин ховор номыг ангилан ялгаж байгаад *Maġma 'al-'Aġā 'ib* нэртэй гар бичмэл цуглуулгын номыг 50-иад оны сүүлээр анх олжээ [7].

Энэ өгүүлэлдээ дундад эртний монгол хэлээр дөрвөлжин үсгээр бичсэн Хувилай сэцэн хааны гэрээсийг нягтлан үзэхийг зорилоо.

*Хувилай сэцэн хааны гэрээсийг олж мэдсэн минь:* Япон улсын ЭнЭйчКэй<sup>6</sup> корпорацийн телевизийн тусгай нэвтрүүлгийн “Өрнө дорнын соёл иргэншлийн солбилцол ба Евроазийг нэгтгэх мөрөөдөл” хэмээх баримтат киног ЮуТюб<sup>8</sup> дээрээс олж үзсэн юм [3]. Уг баримтат киноны төгсгөлийн хэсэгт Ази, Европ хоёр тивийг холбох гүүр хэмээн алдаршсан Турк Улсын эртний нийслэл Истанбул хотын номын сангийн ховор нандин номын архивт хадгалагдаж буй *Maġma 'al-'Aġā 'ib* номын завсраас олдсон цөөхөн мөр Хувилай сэцэн хааны харьцангуй цөөн гэрээсийг богино хугацаанд тайлбарлан үзүүлэв. 1294 онд таалал төгсөхийнхөө өмнө Хувилай сэцэн хаан үр ач нартаа уламжилсан хэмээн ам дамжин яригдаж ирсэн гэрээс энэхүү номын хуудсанд араб гарчиг, уйгар(жин) үсгээрхи түрэг орчуулгатай дөрвөлжин үсгийн дурсгал болон оржээ. Дэлгэцэнд гарч буй болохоор уйгаржин үсгээр бичсэн мөрүүд нь огт гаргагдахгүй, дөрвөлжин үсгээр бичсэн таван мөр тод харагдаж байв. Тайлбарлагч япон хэлээр

「クビライはこう語っています。「我が息子たちよ、帝国を治めるためには人々を力づくで従わせようとしてはならない。何よりも大切な事、それは人々の心をつかむことである。」

хэмээн хэлэх агшинд дэлгэцийн доод дунд хэсэгт англи хэлээр “*Khubilai said: –My sons. To control the Empire, you cannot force the people to follow you. The most important thing is to understand the heart of the people.*” гэсэн тайлбар хөврөн гарч байна. Энэ бичлэгийн утгыг “*Хувилай хаан хэлэхдээ -Хөвгүүд минь ээ, Их улсыг удирдахын тулд хүн ардад хэрхэн дагахыг хүчээр тулгаж үл болно. Хамгийн чухал нь хүн ардын зүрх сэтгэлийг эзэмдэх хэрэгтэй.*” хэмээн монголчиллоо [4]. Дөрвөлжин монгол бичгээр тэмдэглэн үлдээсэн уг гэрээсийг эх хэлээрээ уншихад хэллэг өвөрмөц, утга уянга гүн, тухайн он цагт хүрээд очсон мэт санагдав. Ингээд би орчуулга дамжин гээгдсэн Монголын Юань улсын үеийн монгол хэлний ая хөг, айзмыг уншигч авгай танаа дэлгэн толилуулахыг зорилоо.

*Хувилай сэцэн хааны гэрээсийг тайлан уншсан минь:* Зүүн гар талдаа араб гарчигтай, баруун гар талдаа уйгаржин үсгээр “Цагаадай түрэг” хэл<sup>9</sup>-ээр утгыг нь тайлбарлан бичсэн дөрвөлжин үсгийн гар бичмэлийн таван мөрийн сүүлийн хоёрынх нь хамгийн доод талын хэдэн үг норж бүдгэрсэн тул шууд уншихад амаргүй ч өгүүлбэрийн утга, балархай үсэг,

<sup>5</sup> Sühyel Ünver

<sup>6</sup> NHK –日本放送協会, Nippon Hōsō Kyōkai - Япон мэдээлэл дамжуулах нэгдэл

<sup>7</sup> 東西文明の融合とユーラシア統一の夢

<sup>8</sup> YouTube - богино хэмжээний видео бичлэг үзэх вэб сайт

<sup>9</sup> Цагаадайн эзэн улсын үеэс төв Азид өргөнөөр хэрэглэгдэж байгаад 20 дугаар зууныг хүртэл тус бүс нутагт бичгийн хэлний хэлбэрээр уламжлагдаж ирсэн түрэг хэлний нэг төрөл. Энэтхэгийн мугалууд энэ хэлээр ярьдаг байжээ.

үгийн хэмжээг тооцон үзэж нөхөн сэргээн унших оролдлого хийв. ЮуТюб(youtube) дээрх уг баримтат киноны дүрс бичлэгийг түр зогсоож дөрвөлжин үсгийг дэлгэцэнд байгаа хэмжээгээр нь хуулаад цааш нь дэлгэцээ гүйлгэх аргаар бүх мөрийг гараар хуулан буулгаж авлаа (Зураг 1). Уг бичвэрийг олон улсын эрдэмтдийн жишигээр, латин үсгийн (transliteration) галигаар, профессор Ц. Шагдарсүрэнгийн зарчимыг баримтлан сийрүүлэн буулгавал:

qu-bu-la<sub>0</sub>-yi qa<sub>0</sub>:a<sub>0</sub>n-u ja<sub>0</sub> r-liq bo<sub>1</sub>-lu-run ta<sub>0</sub>·u-ru-ut  
 mi-nu mo<sub>1</sub>-na<sub>0</sub> qo-yi-na<sub>0</sub> ·ul-us ·ir-ge-ni qu-ri-ya<sub>0</sub>-ba<sub>0</sub>-su  
 gesu be<sub>1</sub>-ye-yi ·a<sub>0</sub>-nu qu-ri-ya<sub>0</sub>-ta<sub>0</sub>-la<sub>0</sub> set-gi-li ·a<sub>0</sub>-nu  
 qu-ri-ya<sub>0</sub>-ba<sub>0</sub>-su set'-gi-li ·a<sub>0</sub>-nu qu-ri-ya<sub>0</sub>[č a<sub>0</sub> be<sub>1</sub>-ye]s  
 ·a<sub>0</sub>-nu qa<sub>0</sub>-a<sub>0</sub> ·e-u-ta<sub>0</sub>-qu-na<sub>0</sub> † bi-ra<sub>0</sub>m-ha<sub>0</sub>m[da<sub>0</sub> bi-ba<sub>0</sub> yi] †

болж байна. Үүнийг латин авианы (transcription) галигаар сэргээн сийрүүлбэл:

qubulayi qaan-u jar-liq bolurun ta uru-ut  
 minu mona qoyina ulus irgen-i quriybasu  
 gesu beye-yi anu quriyala set-gi-li anu  
 quriybasu set-gi-li anu qu riya [cha] [beye]s  
 anu qa-a e'üt-qün † biramham[d] [b][i]-[b][a][y][i] †

хэмээн бууж байна. “Бирамхам” гэсэн үг нь уг гэрээсийг тэмдэглэн бичсэн газрын нэр болов уу. Энэхүү гэрээсийг унших эхний оролдлого хийхдээ эхлээд “хааны” гэдэг үгийг Б.Сумъяабаатар<sup>10</sup> багшаас лавлаж, Ц.Шагдарсүрэн<sup>11</sup> багштай зөвлөснөөр уг гэрээсийн эхийг хайхаар шийдэв. Мацукава Такаши<sup>12</sup> багшаас Осман Туна, Жэймс Боссон нарын Хелсинки хотноо 1962 онд хэвлэсэн нийтлэлийн<sup>13</sup> хуулбарыг (Зураг 2) олж авлаа. Өөрийн тайлан уншсан галигаа Осман Туна, Жэймс Боссон нарын галигт харьцуулахад <·u-ru-ut> үгэнд үсгийн алдаа <mon qo-yi<sub>1</sub>n> үгэнд [8] утгын алдаа гаргасан байлаа. Төгсгөлийн хоёр мөрийн балархай үгсийг Жэймс Боссон багшийн<sup>14</sup> галигаас нэмж оруулав. Хамгийн сүүлчийн “бичвэй” гэдэг үгийг уг эхэд үсгийн алдаатай бичсэн тухай Жэймс Боссон багш нийтлэлдээ дурджээ [7], Тус нийтлэлд уйгар(жин) үсгээр түрэг хэлээр бичсэн тайлбарыг монголчилбол “Хубилай хаан үхэхийнхээ өмнө “- Ай хөвгүүд минь ээ, надаас хойш ард иргэдийг хураахдаа тэдний биесийг хураахын оронд тэдний сэтгэлийг хураа. Тэдний сэтгэлийг хураасан хойно биес нь дагаад ирнэ” хэмээн зарлиг болгожээ” хэмээн монголчлож болмоор байна. Түрэг хэлний орчуулгыг дөрвөлжин үсгээс буулгасан галигтайгаа харьцуулан нягтлахад Хубилай цэцэн хааны гэрээс орчин цагийн монгол хэлэнд “Хубилай хааны зарлиг болруун: <-та ур(г)ууд миний мөн(өө) хойно улс иргэнийг хурааваас гэвээс биесийг нь хураатал сэтгэлийг нь хурааваас, сэтгэлийг нь хураачаа биес нь хаа одху(й)н> Бирамхамд бичвэй.” хэмээн бууж байна. Энэхүү галигаа эрдэмтэн Ё.Жанчив агсны галигтай [9] харьцуулахад галиглах арга нь өөр боловч үсгийн галиг ба утга нь үндсэндээ нийлж байна. Гол ялгаа нь нэгд Ё.Жанчив агсан уг бичгийн дурсгалын гэрэл зургийн хуулбарыг ашигласангүй, хэн нэгэн хүний гараар дөхүүлэн буулгасан эхийг [9] ашигласан, хоёрт гэрээсийн сүүлчийн үгийн утгыг “үүтхүн” хэмээн буулгасан байна. Энэ үгийг “одху(й)н” гэж буулгавал зохистой

<sup>10</sup> Монгол улсын ШУА-ийн Хэл утга зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн профессор

<sup>11</sup> МУИС-ийн Монгол судлалын төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор профессор

<sup>12</sup> Япон улсын Кёото хотын Оотанийн их сургуулийн монголч эрдэмтэн, профессор

<sup>13</sup> A Mongolian 'Phags-pa and Its Turkish Translation in the «Collection of Curiosities»

<sup>14</sup> АНУ-ын Кальфорн мужийн Бөрклей дэх Кальфорнын их сургуулийн хэлшинжлэлийн ухааны доктор профессор, монголч эрдэмтэн

санагдлаа. Ц.Шагдарсүрэн багштай зөвлөснөөр Д.Төмөртоого<sup>15</sup> багшийн галигтай [10] тулган үзэж 'n', 'q', 'y' үсгийн дараах 'a' үсгийг нэмэн орууллаа. Д.Төмөртоого багш 'gesu' гэдэг үгийн өмнө ямар нэгэн үг үсэг байсан гэж үзжээ. Зуунаст гуайн галигтай [11] давхар тулгаж үзэхэд 'q' үсгийг 'G'-ээр галигласан нь ялгаатай байв. Дөрвөлжин үсгийн дуудлагийн дагуу Д.Төмөртоого багшийн галигийг дагаж 'q' -ээр галиглав.

**Дүгнэлт:** Япон, англи хэлний орчуулга болон миний буулгасан галиг нь утгын хувьд хоорондоо ойролцоо боловч дөрвөлжин үсгийн эх нь орчин цагийн монгол хэлний ярианы хэлэнд ойрхон, найруулгын хувьд өөрийн гэсэн өнгө аястай аман ярианы өвөрмөц онцлогийг бүрэн илэрхийлж чадаж байна. Бичгийн хэлний дүрэмд баригдалгүй, ухаант Хувилай сэцэн хааны айлтгалыг үгчлэн буулгаж авсан тухайн цаг үеийн ярианы хэлний дурсгал болж буйд уг гэрээсийн эрдэм шинжилгээний ач холбогдол оршино. Энэхүү гэрээст гарах “мөн(өө) хойно” гэдэг ярианы хэлний өвөрмөц хэллэг орчин цагийн монгол хэлний буриад аялгуунд одоо хүртэл уламжлагдан ирсэн нь буриад аялгуу дундад эртний монгол хэлэнд хамгийн ойрхон болохыг нотлох нэгэн баримт болно гэж санаж байна. Төрөлх монгол хэл маань хэдийвээр долоон зууны хувьсал өөрчлөлтийг туулсан ч унаган төрхөө алдаагүй болохыг ухаант Хувилай цэцэн хааны гэрээс давхар гэрчилж байна. Энэхүү бичгийн дурсгал нь яриангүй монголчуудын соёлын өвийн нандин эрдэнийн нэг болно.

**Талархах учир:** Монголч эрдэмтэн Сүгияма Масааки<sup>16</sup> профессортой холбогдохыг зөвлөсөн Уцүми Ёоко<sup>17</sup>, монголч эрдэмтэн Мацукава Такаши профессортой холбож өгсөн Л.Мандхай<sup>18</sup>, Осман Туна, Жэйм Боссон нарын галигийг олж өгсөн Мацукава Такаши профессор, холбогдох судалгааны материалаар хангасан доктор Л.Мөнх-Эрдэнэ<sup>19</sup> тус нийтлэлийг бичихэд үнэтэй зөвлөгөө өгсөн профессор Ц.Шагдарсүрэн багш, профессор Б.Сумъяабаатар багш, профессор Жэймс Боссон багш, эрдэмтэн Я.Баатар<sup>20</sup> нарт гүн талархал илэрхийлье.

### Зүүлт

1. Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичгийн товчоон*, Улаанбаатар 2001.
2. *Пагва үсгийн Монгол хэлээр бичигдсэн дурсгалын эмхтгэл*, Эмхэтгэсэн Хөгжилт, Саруул, Биан Зу, Өвөр монголын Боловсролын хэвлэлийн хороо, Хөх Хот 2004 /八思巴字蒙古语文獻汇编 / 呼格吉勒图, 萨如拉编著. 呼和浩特市: 内蒙古教育出版社, 2004./
3. *Өрнө дорнын соёл иргэнийн солбилцол ба Евроазийг нэгтгэх мөрөөдөл* (東西文明の融合とユーラシア統一の夢), Яг.он улсын ЭнЭйчКэй (NHK) корпорацийн тусгай нэвтрүүлгийн баримтат кино, 2003.
4. Ш. Баатар, Интернэтийн “Хүн сударын шогла дэлгэмү” хэмээх блогт буй нийтлэлийн линк: <http://shbaatar.blogspot.com/2009/12/v.html>
5. Лю Чангпэй, *Пагва үсгээр бичигдсэн Юанийн үеийн хятад хэл*, Хятадын нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо, Бээжин 2004./罗常培. 八思巴字與元代漢語 / 罗

<sup>15</sup> Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал

<sup>16</sup> Япон улсын Кёотогийн их сургуулийн Төв Ази судлалын профессор, монголч эрдэмтэн

<sup>17</sup> Япон улсын ЭнЭйчКэй корпорацийн ажилтан, англи хэлний програмын орчуулагч

<sup>18</sup> Их Бритиан улсын Кэймбрикийн их сургуулийн аспирант

<sup>19</sup> Австри улсын Шинжлэх ухааны академийн Нийгмийн Антропологийн хүрээлэнгийн судлаач эрдэмтэн

<sup>20</sup> Америкийн монголчуудын уран зохиол сэтгүүлч эрхлэгч

- 常培, 蔡美彪編著. 北京 : 中国社会科学出版社, 2004./
6. А.А. Бобровников, *Памятники Монгольского Квадратного Письма*, Санктпетербургъ, 1870.
  7. Osman Netim Tuna, James Evert Bosson, *A Mongolian 'Phags-pa and Its Turkish Translation in the «Collection of Curiosities»*, Suomalais-Ugrilainen Seura, Helisinki, 1962.
  8. *The Mongolian monuments in 'Phags-pa script*, by Nicholas Poppe. Translated and edited by John R. Krueger. Poppe, N. N., O. Harrassowitz; 2nd edition, 1957.
  9. Ё. Жанчив, *Дөрвөлжин үсгийн дурсгал* (Эх үсгийн галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээ, ном зүй), Monumenta Mongolica, Улаанбаатар, 2002 (хуудас 144)
  10. Д.Төмөртоогоо, *Монгол дөрвөлжин үсгийн дурасхалын судалгаа*. VOL II. УБ 2002 (хуудас 66)
  11. Зуунаст, *Пагва бичгийн дурасхалын судалгааны өгүүлэл*, Vol. 2, § 37. 2, Токио 1991. (хуудас 218)

### Summary


#### KHUBILAI KHAN'S LAST WISHES IN MONGOLIAN PH'AGS-PA (SQUARE) SCRIPT

Shirchin Baatar, a visiting scholar in the Khitan studies at the Institute of East Asian Studies at University of California Berkeley.

In the making of the “Khubilai Khan and Mongolian Empire” documentary, the NHK Special program coordinating group rediscovered Khubilai Khan's last wishes, all written on a single page of a Yuan history book that is archived at the Topkapi Palace Museum Library in Istanbul, Turkey. I compared the square script transcription with the Japanese and English translations, and unmasked lost points in the translations. In reading the script, I also analyzed the old Mongolian text and highlighted some of the linguistic changes in the modern Mongolian language through the course of 700 years. As I did the transcription of the text, I captured the meaning of the whole text and filled the damaged portion with the 1962 transcription done by Dr. Osman Tuna and Dr. James Bosson. I realized later that there were other transcriptions done by different people including but not limited to Dr. Yo. Janchiv's, Dr. D. Tumurtogoo's, and Dr. Zuunast's. In order to avoid possible mistakes in transcription on my part, I compared what I came up with theirs. My conclusion is that this document is a living proof of the colloquial Mongolian language and the closeness of the contemporary Buriat Mongolian dialect to the ancient Mongolian language during the Yuan period. Amongst the Mongolian scholars, this text can be categorized and be rediscovered as the newly known document in the Mongolian square script. This document will be of very high value as a research candidate for further studies in the area of Mongolian linguistics and a very good addition to the Mongolian square script collection.

ᠠᠨᠦ ᠨᠠᠭᠤᠨ ᠶᠢᠭᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ  
ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ  
ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ  
ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ  
ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ ᠶᠢᠨᠠᠨ

Зураг 1. Ухаант Хубилай сэцэн хааны гэрээсийг дэлгэцээс гараар буулгасан хуулбар



Зураг 2. Осман Туна, Жэйм Боссон нарын эх болгосон гэрэл зургийн хуулбар